



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/59

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаа
эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1 дэх хэсэг, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжүүдийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай сунгасугай.

3. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

4. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын дөрөвдүгээр хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжүүдийн дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай сунгасугай.

5. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.

6. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д даалгасугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА